



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



From  
the People of Japan



Save the Children  
100 YEARS



НҮБ-ын Хүүхдийн Сан

## ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



Та хүүхдэдээ сургуульд орохын өмнө  
хэрхэн туслах вэ?



Хүүхдийг Ивээх Сан

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ [mongolia.secretary@savethechildren.org](mailto:mongolia.secretary@savethechildren.org)

🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

📘 Save The Children in Mongolia

🐦 Save The Children MN

**Зохиогчид:**

БЗД-ийн “Шавь” цогцолбор сургуулийн Бага боловсролын менежер Д.Ганчимэг  
Бага ангийн багш А.Тунгалагтамир

Улаанбаатар хот  
2020 он

## ӨМНӨХ ҮГ

Эцэг эхчүүд бид хүүхдээ сургуульд бүртгүүлсний дараа хүүхдэдээ хэрхэн туслах ёстой вэ? Энэ асуултад хариулт өгөх зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэлээ. Энэ гарын авлагад хүүхдийн хөгжлийн өргөн агуулгыг багтаахаас илүүтэй хүүхэд сургуульд элсэн суралцахад нэн тэргүүнд анхаарч хөгжүүлбэл зохих чадвар, дадлыг тодорхойлж өгснөөс гадна эцэг эхчүүдийн зүгээс хүүхдэдээ үзүүлэх дэмжлэг, санамж зөвлөгөөг оруулж өгсөн болно.

Зохиогчид

### ГАРЫН АВЛАГЫН АГУУЛГА

1. БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ	
1.1 Хүүхдийн гарын жижиг булчингийн хөгжлийг дэмжих .....	2
1.2 Хүүхдэд эрүүл ахуйн зөв дадал хэвшүүлэх.....	3
2. ХЭЛ ЯРИАНЫ ХӨГЖИЛ	
2.1 Өөрийгөө илэрхийлэх хэл ярианы чадварыг нь дэмжих .....	4
3. СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, НИЙГЭМШИХҮЙ	
3.1 Хүүхэд өөрийгөө үнэлэх зөв хандлагыг дэмжих.....	5
3.2 Хүүхдийн эерэг сэтгэлийн хөдөлгөөнийг дэмжих.....	6
4. ОЮУН УХААН	
4.1 Хүүхдийн ажиглах чадварыг хөгжүүлэх .....	7
4.2 Хүүхдийн бодит болон хийсвэр сэтгэхүйг хөгжүүлэх .....	8
5. СУРАЛЦАХ ЧАДВАР	
5.1 Сурах зөв хэвшилд сургах .....	9
6. ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР	
6.1 Сургуульд дасан зохицоход бэлтгэх .....	12
ХАВСРАЛТ 1 .....	16
ХАВСРАЛТ 2 .....	25
ХАВСРАЛТ 3 .....	28
ХАВСРАЛТ 4 .....	32



# 1. БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ

## 1.1 ХҮҮХДИЙН ГАРЫН ЖИЖИГ БУЛЧИНГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Хүүхэд сургуульд элсэж сурах үйл ажиллагаанд өдөр тутам оролцох болсноор бичих, зурах, наах зэрэг гарын жижиг булчингийн эвсэл, хөдөлгөөн шаардсан үйлдлүүд ихээр хийх хэрэгтэй болдог. Ийм учраас сургуульд орохын өмнө хүүхдийнхээ гарын жижиг булчингийн хөдөлгөөн, эвсэл, уян хатан чанарыг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Зургаан настай хүүхдийн тулгуур эрхтний хөгжил эмзэг үе шатандаа байдаг учраас биенд нь тохироогүй хүнд ачаалал өгвөл гар, хурууны сарвуу, нурууны яс нь буруу хөгжих нь амархан байдаг.

### АНХААРАХ САНАМЖУУД

- Хүүхдийн гар сарвууны жижиг булчингуудын хөгжил сул байдаг учраас дүрс зурах чадвар тааруу байдаг. Иймд зурах, бичих даалгавар удаан хугацаанд хийх үедээ завсарлага авч, гарыг нь амрааж байх.
- Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрс будах дасгал давтаж хийх замаар үндсэн зурлагын гол элементүүдийг зөв бичих дадал эзэмшихэд анхаарах.
- Хүүхдийг бичүүлэхдээ үндсэн зурлагын дагуу үзэг харандааг цааснаас салгахгүйгээр бичүүлж сургахад анхаарах.
- Дэвтрийн шугамандаа багтааж мөр давуулалгүй бичүүлэх дасгал хийх.
- Харандаа, балыг зөв бариулж сургахад анхаарах.



### ШАЛГАХ ХУУДАС

Дугуй дүрсийг үзүүлсэн зааврын дагуу будаж байна уу?	
Дөрвөлжин дүрсийг үзүүлсэн зааврын дагуу будаж байна уу?	
Гурвалжин дүрсийг үзүүлсэн зааврын дагуу будаж байна уу?	
Үзэг харандаагаа барихдаа хуруугаа чөлөөтэй хөдөлгөж чадаж байна уу?	
Үзэг харандааг цааснаас салгахгүйгээр зураас, зурлагыг зурж чадаж байна уу?	

### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

- Өгөгдсөн зураг, дүрсийг доорх зааврын дагуу өнгийн харандаагаар будуулж сургах /Хавсралт 2-ын даалгавар/
  - дүрсийг баруун дээд талаас эхлэн хөндлөн зурлагаар будах
  - дүрсийг баруун дээд талаас эхлэн дээрээс доош чиглэсэн ташуу зурлагаар будах
  - дүрсийг баруун дээд талаас эхлэн дугуй зурлагаар гар салгахгүй будах
- Хүүхдийг бичүүлж сургах гэж яарах хэрэггүй, дармал, бичмэл үсгийг бүтээдэг дугуй, гонзгой шулуун, налуу, босоо зураасуудыг оруулсан дүрс зуруулах, түүнийгээ будах даалгавар өгөх /Хавсралт 1-ийн даалгавар/
- Цаасыг нугалж янз бүрийн дүрс хайчилж наалгах, утсанд товч болон том жижиг нүхтэй зүйлийг хэлхэх, харандаа, эсвэл савх модыг нэг хурууны завсраас нөгөөд дамжуулан тоглох гэх мэт гар, сарвууны булчингуудын хөгжлийг дэмжсэн дасгалууд хийлгэх





## 1.2 ХҮҮХДЭД ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВ ДАДАЛ ХЭВШҮҮЛЭХ

### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Хүүхдийн эрүүл мэндийг бэхжүүлэх, бие организмын хэвийн ажиллагааг хангахад өдрийн дэглэмийг баримтлуулж сургах нь чухал байдаг. Өдрийн дэглэмд нойрсолт чухал ач холбогдолтой. 6-8 насны хүүхэд хоногт 11-12 цагаас доошгүй унтаж амрах шаардлагатай. Хэрвээ хүүхэд тогтоосон хугацаагаар амарч чадахгүй бол нойрны дутагдал үүсч аажмаар анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх, ядарч сульдах, өвдөх зэрэг эрсдэл бий болдог.

6 настай хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтөд хөдөлгөөн онцгой үүрэгтэй. Ялангуяа хөдөлгөөнт тоглоом хүүхдийн бие, эрхтний хөгжилд сайнаар нөлөөлөхийн хамт бодисын солилцоог эрчимжүүлдэг. Түүнчлэн хүүхэд бие дааж хувцаслах, бие засах, хоол идэхийн өмнө болон дараа гараа угаах, шүдээ зөв угаах, нусны алчуур хэрэглэх, эрүүл мэндээ хамгаалах аргыг мэдэж хэрэглэх нь чухал. Мөн шаардлагатай үед гэрийн хаяг, ээж, аавынхаа утасны дугаарыг хэлж чаддаг байх хэрэгтэй.

	 ШАЛГАХ ХУУДАС
	Өдөр бүр тогтмол цагт унтаж хэвшсэн үү?
	Өглөөнийхөө цайг тогтмол уудаг уу?
	Чихэр, газтай ундаа хэрэглэхгүй байхыг хичээдэг үү?
	Шүдээ тогтмол угаадаг уу?

### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

Хүүхдэдээ жишиг цагийн хуваарийг мөрдөж хэвших талаар ярьж өгөх, мөрдөж хэвшүүлэх.

Жишээлбэл: Доорх үлгэрчилсэн хуваарийг 1-р ээлжинд сурдаг сурагчид ашиглаж болно.

06:30 – 07:20	Өглөө босох, ариун цэвэр сахиx, цайгаа уух.
07:20 – 08:00	Сургуульдаа явах.
08:00 – 13:00	Хичээлдээ суух.
13:00 – 14:00	Сургуулиасаа гэртээ ирэх, цайгаа уух.
14:00 – 16:00	Идэвхтэй амралтын цаг.
16:00 – 18:00	Гэрийн даалгавраа хийх.
18:00 – 20:00	Гэр орны ажилд оролцох.
20:00 – 21:00	Чөлөөт цаг /Сонирхдог зүйлээ хийх, телевизор үзэх гэх мэт/.
21:00	Унтах.




## 2. ХЭЛ ЯРИАНЫ ХӨГЖИЛ

### 2.1 ӨӨРИЙГӨӨ ИЛЭРХИЙЛЭХ ХЭЛ ЯРИАНЫ ЧАДВАРЫГ НЬ ДЭМЖИХ

#### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Сургуульд элсэн орсны дараа зургаан настай хүүхдэд бусдад өөрийгөө бүрэн танилцуулах, бусадтай яриа үүсгэж харилцах, багшийнхаа асуултад бүрэн хариулт өгөх, бүтэн өгүүлбэрээр ярих зэрэг чадварууд их шаардлагатай байдаг. Ялангуяа хүүхэд сурах үйл ажиллагаанд гүнзгий оролцож эхэлснээр дасгал, даалгаврыг хийж гүйцэтгэх багшийн зааварчилгааг ойлгох, ойлгохгүй байгаа зүйлээ лавлаж асуух, хийсэн зүйлээ тайлбарлах зэргээр өөрөө өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ гарч ирдэг. Иймд хүүхдийн өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах хэл ярианы чадвар дадлыг хөгжүүлэхэд анхаарах нь чухал. Мөн хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ болон аав, ээж, эмээ, өвөө зэрэг гэр бүлийнхэнтэйгээ өдөр тутам харилцаж, ярилцсанаар хүүхдийн үгийн сан баяжиж байдаг. Тэдний үгийн сан баяжсанаар хэл яриа, сэтгэхүйн хөгжилд ахиц дэвшил гардаг тул эцэг эх та хүүхдийнхээ үгийн санг баяжуулахад анхаарах нь зүйтэй.

Мөн сургуульд орох насны хүүхдэд хэл ярианы бэрхшээл байвал түүнээсээ болж бусдаас ичиж зовох, бусадтай харилцаа үүсгэж ярихгүй зэрэг бэрхшээлүүд тохиолдож эхэлдэг. Иймээс таны хүүхэд хэл ярианы бэрхшээлтэй бол мэргэжлийн багшид хандаж засах, бусадтай нээлттэй харилцахыг нь дэмжиж байх хэрэгтэй.

✓	 ШАЛГАХ ХУУДАС
	Таны хүүхэд өөртөө тохиолдсон үйл явдлаа ярьж чаддаг уу?
	Таны хүүхэд бусадтай ярилцахдаа тавьсан асуултад бүрэн хариулдаг уу? Цааш нь бие даан яриа үүсгэн харилцаж чаддаг уу?
	Үйл явдлын дараалал харуулсан зургийг хараад дэс дараатай ярьж чадаж байна уу?
	Бүтэн өгүүлбэрээр ярьж чадаж байна уу?
	Дараах үгсийг зөв дуудаж хэлж байна уу? Хөсөг, байшин, цас, зузаан г.м (буруу дуудлагын жишээ: хөдөг – хө*г (байдан, тас, дузаан г.м.)

#### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

- Та хүүхдийнхээ яриаг таслахгүй сонсох, тэдний ярих хүсэл сонирхлыг нь дэмжиж байх
- Хүүхдэдээ үйл явдлын дараалал харуулсан зураг харуулж яриулах. Жишээ нь: Энэ зурагт эхлээд ямар үйл явдал дүрслэн үзүүлсэн бэ? дараа нь ямар үйл явдал өрнөсөн бэ? гэх мэт асуултаар чиглүүлэн яриулж сургахад анхаарах
- Хүүхдийн яагаад? гэсэн асуулт тавих бүрт таарсан хариулт өгч тайлбарлаж өгөх
- Хүүхдэд жижиг үлгэр, өгүүллэг ярьж өгч, утгыг нь өөрийнх нь ойлголтоор яриулах
- Хүүхдийн өөрт тохиолдсон явдлыг нь дэмжиж яриулах. Дараа нь энэ тухай энгийн үлгэр зохиолгон яриулаарай. Жишээлбэл: Эрт урьдын цагт ..... гэх мэт
- Хэл зүгшрүүлэх үг хэллэг буюу түргэн хэллэг, жороо үг, шүлэг, зүйр үгийг тогтоолгож хэлүүлэх нь авиа, үг хэллэгийг цэвэр хэлж сурах дасгал болдог гэдгийг санаарай. /Хавсралт 4-ийн даалгавар/





### 3. СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, НИЙГЭМШИХҮЙ

#### 3.1 ХҮҮХЭД ӨӨРИЙГӨӨ ҮНЭЛЭХ ЗӨВ ХАНДЛАГЫГ ДЭМЖИХ

##### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Зургаан настай хүүхэд сургуульд анх элсэн орсноор өөрөө өөрийгөө үнэлэх хэрэгцээ гарч ирдэг. Ялангуяа хүүхэд сурсан зүйлээ эзэмшиж чадсан эсэхээ өөрөө хянах, алдаагаа өөрөө олж засч залруулах болон өөрийн ололт амжилтаа олж харах тухай ойлголтыг үүнд багтаадаг. Энэ насанд хүүхэд өөрийнхөө талаар өөдрөг төсөөлөлтэй байдаг. Жишээлбэл: “Би сайн сурч чадна, их зүйлийг хийж мэднэ” гэх мэт. Хүүхдийн энэ зөв хандлагыг унтраалгүй, дэмжиж урамшуулж хандвал тэд цаашид өөртөө итгэлтэй болох ба өөрийн хүчээ сорих, аз турших, шинийг эрэлхийлэх зөв хандлагатай болж илүү амжилттай суралцахад ихээхэн дэмжлэг болно. Хүүхэд “Би үе тэнгийнхнийхээ чаддаг зүйлийг хийж чадна” гэсэн итгэлтэй байх үед л тэдний өөрийн үнэлгээ, хандлага нь зөв зохистой хөгждөг гэдгийг санаарай.

Эцэг, эхчүүд доорх асуултуудын дагуу хүүхэдтэйгээ ярилцаж тэдний өөрийгөө үнэлэх хандлагыг тодруулаарай.

	 ШАЛГАХ ХУУДАС
	Чи хамгийн сайн чаддаг зүйлээ хэлж өгнө үү?
	Чи бусдаас илүү юуг сайн хийж чадах вэ?
	Чиний хийсэн даалгаварт дутуу зүйл байна уу?
	Чи хийсэн даалгавраа хэрхэн үнэлж байна вэ?

##### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ



- Хүүхэд ихэвчлэн өөрийг нь үнэлсэн насанд хүрэгчдийн үнэлгээг баримжаалдаг учраас тэдэнд дандаа сайшаал, урам, дэмжлэг, итгэл хүлээлгэх харилцаа бий болгох
- Хүүхдийнхээ хийж байгаа үйлдэл болгоны давуу талыг нь харж үнэлж урамшуулдаг байх
- Энэ насны хүүхдүүд тэдний хийсэн зүйлийг сөргөөр үнэлэхэд тэд өөрийг нь бүхэлд нь үнэлж байгаа мэтээр хүлээн авдаг учир сөрөг үнэлгээ өгөхөөс болгоомжлох
- Хүүхэд тань бусад хүүхэдтэй адилхан байх нь чухал бус харин бусад хүүхдээс юугаараа өөр байгааг илрүүлж түүнд нийцсэн сэтгэл зүйн урамшуулал, дэмжлэг үзүүлж байх
- Мөн та хүүхдэдээ өдөр бүр урмын үг хэлж, дэмжлэг үзүүлж чадаж байгаа эсэхээ бодож үзээрэй.



## 3.2 ХҮҮХДИЙН ЭЭРЭГ СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖИХ

### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Хүүхдэд эерэг сэтгэлийн хөдөлгөөнийг төлөвшүүлэхэд насанд хүрэгчид болон үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцаа чухал нөлөөтэй байдаг. Ялангуяа тэдний эерэг харилцаа, халамж, хүндлэл зэрэг нь хүүхдэд дотно, эерэг мэдрэмжийг бий болгож, өөртөө итгэх итгэлийг өгч байдаг. Зургаан настай хүүхэд бусдын сэтгэлийн хөдөлгөөн, өөрт нь хандах хандлагыг ойлгож, өөрийн хэрэгцээ, ашиг сонирхлын үүднээс үнэлэх, дүгнэлт хийх чадварт суралцаж байдаг ба аажмаар өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг жолоодох чадварт суралцдаг. Ийм учраас эцэг эх та хүүхдийнхээ хийсэн үйлдэл, зан авирыг бодитойгоор үнэлэх, өөрт нь ойлгуулах, тэдэнтэй өдөр тутам тогтвортой эерэг харилцах нь чухал.

	 ШАЛГАХ ХУУДАС
	Хүүхэд тань өөрийнхөө тааламжгүй байдлыг бусдад илэрхийлж чаддаг уу?
	Хүүхэд тань бусдын тааламжгүй сэтгэлийн хөдөлгөөнийг мэдэрдэг үү?
	Хүүхэд тань бусдад баярласан талархсанаа тогтмол илэрхийлдэг үү?
	Уучлаарай, ингэж болох уу? тэгж болох уу? гэдэг үг хэллэгийг хэрэглэдэг үү?

### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

- Эерэг сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжийг бий болгоход тэдэнтэй харилцах эцэг эхийн харилцаа хандлага, үлгэр дуурайл чухал гэдгийг санах
- Бусадтай сэтгэлийн хөдөлгөөнөө үг яриагаар дамжуулан ойлголцдог байхад анхаарах
- Хүүхэд өөрийнхөө үйлдлийг хянадаг болгоход туслахын тулд тэдэнтэй өөрийнх нь гаргасан зан авирын талаар эелдэг дотно ярилцах
- Хүүхдийг бодитой үнэлж дүгнэх. Жишээлбэл: Сайн байна, мундаг байна гэхээсээ илүүтэй
  - Чи энэ үлгэрийг үйл явдлын дарааллаар ярьж чадаж байна
  - Чи энэ дүрсийг илүү гаргахгүй будаж чадна
  - Чи алдаагаа олж харж чадаж байна гэх мэтээр дүгнэж хэлэх нь чухал.



## 4. ОЮУН УХААН



### 4.1 ХҮҮХДИЙН АЖИГЛАХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ

#### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Хүүхдийн зургаан нас бол мэдрэхүйн эрхтнүүд нь хөгжиж, юмс үзэгдлийн гадаад шинж чанар болох дүрс, хэлбэр, өнгийг бодит байдлаар нь таньж мэдэх үе юм. Ингэхдээ тэд юмсын гол шинж чанарыг олохгүй тохиолдлын шинж чанарыг олох, мэддэг дүрсийг нь өөрөөр байрлуулахад танихгүй байх тохиолдол олонтоо тааралддаг. Хүртэхүйн задлан ялгах шинж сул хөгжсөн байдаг тул юмсыг ажиглах үедээ анхаарлыг нь татсан хурц тод, шууд нүдэнд нь харагдах зүйлд анхаарлаа төвлөрүүлээд гол зүйлийг нь орхигдуулдаг байна.

Иймд юмсын ижил төсөөтэй шинж чанарыг ялгаж ажиглах чадвар хангалтгүйгээс ойролцоо дүрстэй үсэг, цифр тэмдэгт, тоог хольж солих алдаа гаргадаг. Тэдэнд авиа үсэг таниулахаас өмнө юмсын ижил ба төсөөтэй зүйлийг ялган хүртэх /харах, сонсох/ чадварыг хөгжүүлэх нь чухал.

✓	 ШАЛГАХ ХУУДАС
	 <p>Зурагт ямар хэлбэр дүрстэй, өнгөтэй зүйлс байна вэ?</p>
	Таны хүүхэд дүрсийг хэлбэр, хэмжээ, өнгө, зориулалтаар нь ялгаж харьцуулж чадаж байна уу?
	10 хүртэлх тооны цифрийг оноож тоолж, бичиж чаддаг уу?
	Өөрийн нэрийг бичмэлээр бичиж чадах уу?

#### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

- Юмсын ижил ба төсөөтэй шинж чанарыг ялган хүртэх чадварыг дэмжсэн ажиглах, харьцуулалт хийх даалгавар гүйцэтгүүлнэ. /Хавсралт 3-ын даалгавар/  
Даалгаврыг дараах жишиг заавраар гүйцэтгүүлнэ
  - Хүснэгт доторх дүрсийг ажиглуулна.
  - Доорх асуултын дагуу тоолуулна. Хүүхэд дүрсийг хэдий чинээ хурдан ялган тоолж байвал ажиглах чадварын түвшин ахиж байна гэж тооцно.
    - 1. Хэдэн том дугуй дүрс байна вэ? 2. Хэдэн жижиг гурвалжин дүрс байна вэ?
    - 3. Хэдэн зуйван дүрс байна вэ? 4. Хэдэн жижиг дугуй дүрс байна вэ? гэх мэтээр асууна.
- Хүүхдээрээ аливаа юмс, үзэгдлийг сайтар ажиглуулаад, жишиж харьцуулах байдлаар юмсын ижил ба ялгаатай талуудыг олуулж сургахад анхаар
  - Төрөл бүрийн дуу чимээг хуурцагт бичээд сонсож юуны дуу чимээ болохыг хэлүүлэх.






## 4.2 ХҮҮХДИЙН БОДИТ БОЛОН ХИЙСВЭР СЭТГЭХҮЙГ ХӨГЖҮҮЛЭХ

### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Энэ насны хүүхэд харах, үнэрлэх, сонсох, амтлах, барих гэсэн 5 мэдрэхүйн тусламжтайгаар юмсын шинж чанарыг хүртэж таньж мэдэх үйлдэл зонхилж байдаг бөгөөд аливааг бодит үйлдэл, дүрс, загваруудад тулгуурлан ойлгох хандлагатай. Тиймээс тэдний бодит сэтгэхүйн үйлдэл дээр тулгуурлан хийсвэр сэтгэхүйг хөгжүүлэх шаардлагатай байдаг. Ялангуяа хүүхэд эрэмбэ дараатай, цэгцтэй хэлбэрээр нэгтгэн дүгнэх чадвар сул байдаг тул энэ талын чадварыг дасгал даалгавраар хөгжүүлэх шаардлагатай.

Энэ насанд хүүхэд ямар нэг зүйлийг хүртэж мэдрэхдээ тухайн юмсыг бодитоор орлуулан сэтгэх үйлдэлд тулгуурлан хийсвэрээр ургуулан бодох чадварт суралцаж байдаг. Тийм учраас хүүхдийн хийсвэр сэтгэхүйг хөгжүүлэхийн тулд олон удаа давтах, өөрийнх нь мэддэг зүйлтэй нь холбож дүрслэх зэрэг аргыг хэрэглэвэл илүү үр дүнтэй байдаг.

✓	 ШАЛГАХ ХУУДАС
	<p>Ямар дүрс, юуны зураг байгааг ажиглаж хэлнэ үү?</p> <div data-bbox="790 846 1226 1137" style="border: 1px solid black; padding: 5px;">  </div>
	<p>Дээр тодруулсан 3 дүрсийг доорх дүрсүүд дотроос ялган олж чадах уу?</p> <div data-bbox="790 846 1226 1137" style="border: 1px solid black; padding: 5px;">  </div>

### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

- Хүүхдэд ямар нэг шүлэг, зохиолыг тогтоолгохын тулд түүний утга санааг сайн ярилцаад зурах, баримлын шавраар бүтээх зэргээр загварчлан бодитоор хийж үзүүлбэл амархан ойлгож чээжилнэ.
- Тоо тооллыг бодит хэрэглэгдэхүүн дээр тоолуулж сургах. Ингэж бодитоор сайн хүртэж мэдэрч байж хүүхэд дараа нь тооны хийсвэр үйлдлийг хийж чадна.
- Юмсын ижил ялгаатай зүйлийг олохын тулд ажиглах, харьцуулах, жиших гэх мэт сэтгэхүйн үйлдлийг хийлгэж байх. Жишээ нь: Хүүхдээр хавсралт дасгал ажлуудыг зааврын дагуу хийлгэнэ /Хавсралт 3-ын даалгаврууд/.

## 5. СУРАЛЦАХ ЧАДВАР



### 5.1 СУРАХ ЗӨВ ХЭВШИЛД СУРГАХ



#### ЮУГ АНХААРАХ ВЭ?

**Хүүхэд сурах арга барилд суралцахын тулд гэртээ дараах үйлийг хийж хэвших хэрэгтэй.**

- Хүүхэд гэртээ хичээл даалгавраа хийхийн өмнө ширээн дээр ном, сурах бичиг, дэвтэр, үзэг, харандаа шугам зэрэг хичээлийн хэрэглэгдэхүүнийг гаргаж эмх цэгцтэй байрлуулж сурах
- Ном, дэвтрээ цэвэрхэн эдэлж хэрэглэх
- Гэрийнхээ даалгаврыг тогтмол цагт хийж хэвших
- Өөртөө тохирсон биелүүлж чадах цагийн хуваарь гаргаж мөрдөх

#### Ном сурах бичигтэй ажиллах

- Ном сурах бичиг дээрх дасгал даалгаврын заавар, таних тэмдгийг ажиглах, ойлгох, дарааллын дагуу зөв хийж гүйцэтгэх
- Номын хуудсыг болгоомжтой эргүүлэх
- Номын хавчуурга хэрэглэх
- Номон дээр хэрэгтэй зүйлээ харандаагаар бүдэг тэмдэглэх
- Номын хуудсан дээр үзгээр бичихгүй байх
- Номын хуудсыг нугалахгүй байх

	 ШАЛГАХ ХУУДАС
	Таны хүүхэд өөрт тохирсон цагийн хуваарийг мөрддөг үү?
	Таны хүүхэд хэрэглэсэн номоо буцааж байранд нь тавьдаг уу?
	Номон дээрх зургийг хараад ойлгохгүй зүйлээ танаас асуудаг уу?
	Хүүхэд чинь тогтмол цагт унтаж хэвшсэн үү?
	Хүүхдэдээ хичээл хийх тусгай орчинг гэртээ бүрдүүлж өгсөн үү?

#### ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ



- Та гэртээ хүүхдэд зориулсан сурах орчныг /сандал, ширээ, гэрэл, номын сан гэх мэт/ бүрдүүлж өгөх хэрэгтэй. Ингэж чадвал хүүхэд сурах хөдөлмөрт сонирхолтой, хүндэтгэлтэй хандаж сурдаг.
- Ном, сурах бичиг дээрх дасгал даалгаврын тайлбарыг эхлээд өөрсдөөр нь ажиглуулж юуны тухай болон, хэрхэн хийж болохыг ярилцах боломж олгох.
- Цагийн хуваарийг хийхдээ өөртэй нь хамт ярилцаж хийх. Жишээлбэл: Зурагтаар ямар нэвтрүүлгийг хэдэн цагт үзэхээ хөтөлбөр дээр тэмдэглэж тохиролцох гэх мэт.
- Хүүхдийн унтаж амрах хугацааг хоногт 11-12 цаг байхаар цагийн хуваарьт нь тусгах.



## ЮУГ АНХААРАХ ВЭ?

Хүүхдийг суралцах үйл ажиллагаандаа хариуцлагатай, сурах хүсэл эрмэлзэлтэй, даалгавраа цэвэр нямбай, цаг хугацаанд нь хийж гүйцэтгэж сурах зэрэг зөв дадал, хэвшилд сургаж чадвал эдгээр нь насан туршийн чадвар болон төлөвшдөг. Үүний тулд доорх зүйлсийг сургуульд орохоос нь өмнө та хүүхэдтэйгээ хамтран хийж байх нь тэднийг бие даан сурах аргад суралцахад тус дөхөмтэй байх болно.

- Хийсэн дасгал даалгавраа шалгаж, буруу зүйлээ өөрөө олж засах.
- Дутуу ойлгосон зүйлээ бусдаас асуух.
- Хийж чадсан зүйлээрээ бахархаж, өөртөө урамших.

	 ШАЛГАХ ХУУДАС
	Таны хүүхэд үзэг харандаагаа зөв барьдаг уу? (Үзгийг эрхий, долоовор, дунд гурван хуруугаараа барих бөгөөд долоовор хурууны хөдөлгөөн чөлөөтэй байхаар барина)
	Ширээнд зөв цэх суудаг уу?
	Дасгалын зааврыг өөрөө ажиглаж хийх дарааллыг ойлгохыг чармайдаг уу?
	Яагаад? Ямар учраас гэх мэт асуултыг асуудаг үү?
	Анхаарлаа нэг зүйлд 5-10 минут төвлөрүүлж чаддаг уу?
	Ойлгоогүй зүйлээ бусдаас асуудаг уу?

## ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

Эцэг эх хүүхдэдээ даалгавар хийх дараах дарааллыг ойлгуулж хэвшил болгох.

- Багшийн гэрийн даалгаварт юу өгсөн, түүнийг яаж хийх тухай сонсож ойлгож авах.
- Даалгавар хийхэд шаардагдах хэрэглэгдэхүүнийг бэлтгэж тавих.
- Даалгавар хийхдээ анхаарлаа төвлөрүүлсэн байх.
- 20-30 минут тутамд 10 минут амарч байх.
- Хичээлүүдийн даалгаврыг хийхдээ өөртөө тохирох дараалал тогтоох.
- Даалгаврыг хийж дуусаад заавал өөрөө шалгах.
- Гэрийн даалгаврыг тогтмол цагт хийлгэдэг байх. Жишээлбэл: 9 - 11 цаг, 14 - 16 цаг гэх мэт.
- Гэрийн даалгавар хийхдээ аятай тухтай орчин бүрдүүлсэн байх.

## ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

Хүүхэд гэртээ хичээл даалгавар хийхдээ зөв сууж, дэвтэр, үзгээ зөв хэрэглэж хэвших нь чухал байдаг. Иймд эцэг, эх та дараах зөв хэвшлийг сургасан байх хэрэгтэй.

1. Сурагчдын ширээ нь тэдний насанд тохирсон байх
2. Сурагчид суухдаа хөлөө өвдгөөрөө тэгш нугалан, улыг нь ширээний хөндлөвч дээр тавьсан байх
3. Гарыг тохойноос урагш байх хэсэг ширээн дээр байрлуулж, зүүн гараараа дэвтрийг хөдөлгөхөөргүй тогтоож байхаар байрлуулах. Солгой гартай хүүхдийн хувьд баруун гар энэ үүргийг хүлээнэ.
4. Толгой цэх байж, нүд дэвтэр хоёрын хоорондын зай 25-30 см байх
5. Цээжээрээ ширээнд хэт тулж суухгүй, энэ хоорондын зай 2 см орчим байх
6. Дэвтрийг баруун гар тийш 60-70 градус хазгай байхаар байрлуулах. Солгой хүүхдийн хувьд зүүн гар тийш ийм хэмжээтэй байрлуулах



## Хүүхдээ сурах арга барил эзэмшихэд туслахад ямар зарчмыг баримтлах вэ?

### ■ Дахин дахин давтана

Энэ насны хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогоос хамаарч аливааг олон дахин хийж дадлагажин чадварждаг юм. Гэхдээ ядраах, залхаахгүй аргаар хандахад анхаарах.

### ■ Дагуулж сургана

Аливаа зүйлийг хийж сурах арга алхмуудыг хүүхэдтэйгээ хамтдаа хийж гүйцэтгэж, бие даан хийх дадал олгох.

### ■ Өдөр бүр хүүхдэдээ зориулж цаг гаргана

Гэр бүлийн гишүүд хүүхдээ суралцах болон сургуульд дасан зохицох хүртэлх хугацаанд цагийн хуваарь гарган багштай хамтарч ажиллах.

### ■ Сурах орчинг бий болгоно

Хүүхэд гэртээ хичээл, даалгавраа хийх аятай тухтай орчин бий болгох.

### ■ Хүүхдийнхээ нас бие сэтгэхүйн онцлогийг санана

Тэдний сэтгэц, танин мэдэхүйн онцлогтой танилцаж тэднийг хүлээн зөвшөөрч байх.

### ■ Тэдэнд бэрхшээл тохиолдсон үед хамтдаа гэдгийг ойлгуулна

“Хэрэв миний хүү/охинд бэрхшээл учирвал ээж, аав, ах, эгч зэрэг гэр бүлийн гишүүд ойлгож, тусална” гэдгийг хэлж ойлгуулах.



## 6. ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР

### 6.1 СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХОД БЭЛТГЭХ

#### ЮУГ АНХААРАХ ВЭ?

Хүүхэд сургуулийн шинэ орчин, дэглэмд хэдий чинээ хурдан дасан зохицох нь тэднийг цаашид сургуульд амжилттай суралцахад чухал нөлөө үзүүлдэг.

Хүүхэд сургуульд орсноор дараах зүйлд дасан зохицох шаардлагатай болдог.

- Ангийн найз нөхөдтэй харилцах
- Хичээлийн дэг, цагийн хуваарь
- Сургууль, ангийн орчин
- Ном, сурах бичиг хичээлийн хэрэгсэл
- Сургууль, ангийн дүрэм журам
- Сурах арга барилд суралцах

Хүүхэд сургуулийн орчин, сурах үйлд дадаж суралцаагүйгээс амархан ядрах, бусадтайгаа харилцаж чадахгүй байх, самбарын өмнө гарч асуултад хариулахаас ичих, айх, сурлагаар хоцрох, сургуульд суралцах хүсэл сонирхолгүй болох гэх мэт бэрхшээл гардаг. Иймээс хүүхдийг сургуульд сэтгэл санаа, эрүүл мэнд, бие хүний төлөвшлийн хувьд бэлтгэх нь чухал юм.

Хүүхэд сургуульд орсноор сургуулийн өмнөх чөлөөт байдал нь шинэ дүрэм дэглэмд захирагдах харилцаагаар солигдоно. Хүүхдэд тавигдах шаардлага нэмэгдэж, “Юу хүсэж байна вэ?” гэдгээс илүү “Юу хийх ёстой вэ?” гэсэн байр сууринд шилжинэ. Үүнээс үүдэн харилцааны дараах өөрчлөлтүүд гарч ирдэг.

- Гэр бүл дотроо хүүхэд, цэцэрлэгийн бяцхан хүүхэд биш харин сургуулийн сурагч боллоо гэсэн ойлголтоор солигдоно.
- Хүүхэд багшийн хооронд харилцааны цоо шинэ хэв маяг тогтоно. Жишээлбэл: Гэрийн даалгавраа шалгуулах, бусдынхаа өмнө гарч ярих, багшийн асуултад хариулт өгөх г.м
- Үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны хэв маяг өөрчлөгдөж олон хүүхдүүдтэй шинээр танилцаж, нөхөрлөх, тэднийг ойлгох шаардлага бий болно.
- Ангийн сурагчдын дунд хүүхдийн эзлэх байр суурийг тодорхойлох гол хэмжүүр нь сурлагын амжилт болж эхэлдэг.



#### ШАЛГАХ ХУУДАС

Таны хүүхэд эцэг эхээсээ тусдаа удаан байж чаддаг уу?

Хүүхдүүдийн өмнө гарч өөрийнхөө тухай ярьж чадах уу?

Сургуулийн орчныг урьдчилан танилцуулж харилцан ярилцсан уу?

Хүүхэд шинэ зүйлийг олж мэдэж түүнээсээ баяр хөөрийг мэдэрч байгаа нь ажиглагдсан уу?

## ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ АРГА ЗАМ

- Хүүхдээ сургууль эхлэхээс өмнө сургуулийн орчинд дагуулан явж танилцуулах
- Дасан зохицоход шаардлагатай дээрх хүчин зүйлийн талаар хүүхдийн өөрийнх нь төсөөлөл ойлголтыг яриулах, тайлбарлаж өгөх
- Хүүхдийн хийж бүтээж байгаа үйл болгонд нь урам дэм өгч өөртөө итгэх итгэлийг нь дэмжиж байх
- Хүүхдийнхээ сайн, мууг өөчилж хэлэхээсээ илүү чадаж байгаа зүйлийг нь бахархан хэлэх
- Хүүхдийн орчинтойгоо харилцах харилцаанд илрэх өөрчлөлтүүдийг тэдэнд учирлан ярьж ойлгуулах
- Сургуульд мөрддөг дэг журмын талаар тайлбарлаж өгөх. Жишээлбэл: Ангидаа дэг мөрдөхгүй бол замбараагүй байдал бий болох, шуугилдах, бусадтайгаа муудалцах, мөргөлдөх, гэмтэл бэртэл авах, хичээлээ ойлгохгүй байх, ядрах гэх мэт
- Өөртөө үйлчлэх чадварыг эзэмшүүлэх. Жишээлбэл: Өдөр тутам дараах үйлдлийг хийлгэж хэвшүүлэх
  - Цамц болон хувцсаа товчилдог
  - Гутлаа үддэг
  - Өөрөө хувцсаа өмсдөг
  - Өөрийгөө танилцуулдаг
  - Өөрийнхөө хичээлийн хэрэглэгдэхүүнийг хэрэглээд буцааж байранд нь тавьдаг, саванд нь хийдэг.




## ГАРАА ХЭРХЭН УГААХ ВЭ?

Хүүхдэд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд гараа байнга сайтар угаах талаар эцэг эх та сайн зааж өгөөрэй. Сургуульд элсэн орохоор бэлтгэж байгаа хүүхэд гараа зөв угаах дадалд сурах нь чухал.

### 1. Доорх зургуудыг хүүхдэдээ ажиглуулж зураг тус бүрд юуг дүрсэлснийг ярилцаарай.




### 2. Дээрх зургуудаас дараах дараалалд аль аль нь байх ёстойг хүүхдээсээ асууж зөв байрлуулахад нь туслаарай.





## ГАРАА ХЭЗЭЭ УГААХ ВЭ?

1. Хүүхдээсээ гараа хэзээ угаадаг болохыг асуугаарай. Гараа яагаад угаадаг вэ гэсэн асуултыг тавьж юу гэж хариулахыг нь сонсоорой. Хариултыг буруу эсвэл зөв гэж дүгнэхээс зайлсхийгээрэй.
2. Дараах зургуудыг хүүхдээрээ ажиглуулж зураг тус бүрт юу дүрсэлснийг эхлээд хүүхдээрээ хэлүүлээрэй. Хүүхдэд тань таны туслалцаа шаардлагатай бол зургийг тайлбарлаж өгөөрэй.



### ШАЛГАХ ХУУДАС



Номоо хаагаад хүүхдээсээ гараа хэзээ угаах хэрэгтэй билээ гэдгийг асууж хэр ойлгосныг шалгаарай.















# ХАВСРАЛТ - 1








ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:

Зураасыг шугаманд баримжаалан үзэг, харандаа салгахгүйгээр зурна.









ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:  
Үсгийн зурлагыг дэврийн шугамыг гүйцээн бичнэ.

/// /// ///

/// ///

///

///

///

///

llll

ll

llll

ll

ll ll

ll

ll ll

ll

ll



**ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:**  
Үсгийн зурлагыг дэвтрийн шугамыг гүйцээн бичнэ.

o o o

o o

o o

oo oo

oo

oo

o o o

c c c

c

c

cc cc

cc

cc cc

cc

cc



ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:

Үсгийн зурлагыг дэвтрийн шугамыг гүйцээн бичнэ.

/// //

/// //

///

fff

ff

vvv

vv

lll

ll

rrr

rr

zzz


zz

mm

ffz fzf



**ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:**  
Дүрсийг дэвтрийн шугамыг гүйцээн зурна.











**ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:**  
Дүрсийг дэвтрийн шугамыг гүйцээн зурна.





ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:  
Дүрсийг дэвтрийн шугамыг гүйцээн зурна.






ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:  
Зургийг дүрс будах аргаар будна.




1









2




3




4



5



6







## ХАВСРАЛТ - 3




**ДААЛГАВАР ХИЙХ АРГАЧЛАЛ:**  
Ажиглан харж зааврын дагуу зурж тэмдэглэнэ.

**1** Дараах хүснэгтэд хэдэн дүрс байгааг тоолж тохирох нүдэнд цэгээр тэмдэглэнэ.





**2** Дараах хүснэгтэд хэдэн дүрс байгааг тоолж тохирох нүдэнд тоог бичнэ.



**3** Дараах амьтдын дарааллыг ажиглаад дугаарыг тоогоор тэмдэглэнэ.










4 Ижил дүрстэй зургийг сонгож тохирох нүдэнд зураарай.





5 Зургийг ажиглаад, цонхны зүүн, баруун талд юу байгааг тэмдэглэнэ.





		
	✓	
		
		
		
		

**6** Дүрсийг гүйцээн зурж, будна.



**7** Дүрсийг ажиглаад гүйцээн зурж, будна.






8

Сурагчийн цүнхэнд юу байж болохыг тэмдэглэнэ.



9

Шүдэнзний модыг ашиглан дүрс бүтээнэ.





### ЦЭЭЖЛЭХ ТҮРГЭН ХЭЛЛЭГ

Багшаараа заалгаж  
Багсаараа будав

Галд түлчихэв  
Гарт түрхчихэв

Алга байсан  
Алаг бяруу  
Араг мөргөж  
Тэрэг шөргөөв.

Шилж олсон шүр  
Ширж оёсон ширдэг

Ширмэн тогоо, ширмэл ширдэг  
Ширэн богц, шилэн бөгж

Цас, цаас, царс  
Цав цагаан  
Зос, зэс, цус  
Цөм улаан

Хөрш өвөө  
Хөрс шороо

Бударсан цас  
Бутарсан цаас  
Буталсан зоос

Тээр дээр  
Шир, сээр, шийр гурав  
Тээр доор  
Сэрээ, хөрөө, араа гурав

Уулын буга  
Ууландаа урамдана  
Улаан бух  
Уурандаа урамдана

Хушуу хуруу эрүү гээд  
Хушуу хуруу эрүүгээ  
Бушуу өөрөө заагаарай

Хусаар сүх ишилбэл бөхүү?  
Хушаар сүх ишилбэл бөх үү?

Үүр цайлаа  
Үүл цайрлаа

Зургаан тивийн  
Зураасан зургаас  
Зургаан тивийг  
Зурсан хилээр нь  
Салгаж зааглуулж  
Зурж үзлээ

Даллуур даллаж зурам агналаа  
Баллуур баллаж зураг зурлаа

Ээжийн илүүр, хайруул, бариул гурав  
Эгчийн ээрүүл, хайруул, баллууур гурав

Мөнгөн хонх  
Хөнгөн хонх  
Ганган данх  
Нимгэн лонх

Далангийн энгэрийн  
Далан цагаан гэрийн  
Дан цагаан  
Даавуу бүрээс

Хөрш айлын өвөө өөрөө  
Хөрш шороо ухаад  
Нарс царс тарилаа

Жамц чамд цамц оёж өгсөн  
Жамцын оёж өгсөн цамц чамд байгаа юу?

Бид будан дунд  
Модонд гарав  
Тэд манан дунд  
Хаданд хүрэв

Тураг тулга туурга гурав  
Тэрэг эрэг төлөг гурав

Шээзгий ээзгийг  
Шаазгай нууцгай зөөлөө

## ЦЭЭЖЛЭХ ШҮЛЭГ

### Ширээнд яаж суух вэ?

Шинэ сурагч чи  
Ширээндээ зөв суу  
Асуултын тэмдэг шиг бүү суу  
Анхаарлын тэмдэг шиг цэх суу  
*Ж.Дашдондог*

### Харандаа дэвтэр

Нарийн гоё харандаа  
Нандин сайхан дэвтэр  
Хичээлийн чухал хэрэглэл  
Хэзээ ч бидэнд тустай  
Хазаж үмхэж суувал  
Хайртай харандаа минь хагарна  
Дэндүү гамгүй байвал  
Дэвтэр минь халтар болчихно  
Харандаа дэвтэр байхгүй бол  
Хаана юугаараа бичих вэ?  
Хичээл номоо бичихгүй бол  
Хэзээ ч олигтой сурахгүй  
*Т. Жамьянсүрэн*

### Дэгдээхий

Дэггүй дэгдээхий  
Дэрсэнд нуугдан  
Алаг муурыг  
Айлгахыг хүлээлээ  
Өдрийн нар  
Ууланд нуугдахад  
Өөрийн гэрээ  
Хайсаар гүйлээ.

*Ж.Дашдондог*

### Таван настай хүү

Таван настай жаахан хүү  
Тоо ерөөсөө заалгаагүй байж  
Таван хуруугаа төвөггүй тоолдог юм  
Манайхан бүгдээрээ тав гэнэ  
Өөрийнхөө өндрийг ч тавын тоо гэнэ  
Өөрийн насаа ч тав гэнэ  
Эрхий хуруугаа аав гэнэ  
Долоовор хуруугаа ээж гэнэ  
Дунд хуруугаа ах гэдэг  
Ядам хуруугаа эгч гэнэ

Ийм хүү манайд байхгүй гээд  
Чигчий хуруугаа чимээгүйхэн дардаг  
Эрхий шигээ эр хүн болно гээд  
Таван настай жаахан хүүгийн  
Тавлаж хэлсэн шүлэг энэ  
*Ц.Нүрээд*

### Хавтасгүй ном

Хавтасгүй ном  
Хайран  
Хумсгүй хуруу шиг  
Хулчгар  
Хатуу хавтастай  
Номноос айна  
Харандаа, үзэг  
Балнаас эмээнэ  
Хуудсаа уруулна гэж  
Хулчийна  
Хуйлартал даруулна гэж  
Хургана  
Хумсаа лав авахаар  
Хуруу гэдэг эмзэг  
Хавтасгүй ном гэдэг  
Харин түүнээс ч эмзэг  
*Д.Батжаргал*

### Баярлана даа

Сайхан цагаан шүдээ  
Сайн гэгч нь угаалаа  
Сайхан үнэртэй оогоор  
Сойздон сойздон угаалаа  
Жижигхэн цагаан шүдээ  
Жинтэй сайн угаалаа  
Жимсны амттай оогоор  
Сойздон сойздон угаалаа  
Инээхэд минь инээдэг  
Энгүй цагаан шүд минь  
Эзгийг ааруул иддэг  
Энхрий надад баярлана даа  
Идэхэд минь урамтай  
Эрүүл цагаан шүд минь  
Үргэлж арчилж байдаг  
Эзэн наддаа баярлана даа  
*Д.Пүрэвдорж*



## ЯРИХ, СОНСОХ ҮЛГЭР

### МЭЛХИЙНЭЭС АВРАГДСАН НЬ

Эрт нэгэн цагт аймшигт ган гачиг болжээ. Хамаг гол мөрөн ширгэж, тэнгэрт нэг ч үүл үгүй болов. Хүн амьтан цөмөөрөө шатам халуунаар төөнөх нарыг ширтэн түгшиж суух боллоо. Гэтэл бүх голын усыг урьд хожид үзэгдэж байгаагүй нэгэн аймшигт том мэлхий бүгдийг уучихсан юмсанж. Араатан жигүүртэн бүгд цугларч хэлэлцээд: “Энэ аварга мэлхийг инээлгэж чадвал балгасан тэр их усыг буцаан гаргана. ...Өөр арга байхгүй” гэж тогтжээ. Ингээд түүний өмнө тогоруу бүжиглэж, имж инээдтэйгээр үсэрч харайж, яаж ч оролдоод мэлхийг инээлгэж чадсангүй. Мэлхий амаа чанга гэгч нь жимийчихээд огтхон ч инээсэнгүй гэнээ. Харин тэгтэл хамгийн жижигхэн өт өнөөх мэлхийн том гэдсэн дээр гараад сүүлээрээ түүнийг гижигдэж гарчээ. Том мэлхий эхлээд ихэд тэвчсэн авч удалгүй тэсвэр алдаад инээж гарав. Түүнийг инээмэгц залгисан бүх ус нь хүрхрээ болон асгарч, ангаж цангасан амьтан, хүмүүс аврагдаж амар сайхандаа жаргажээ.

### ЦЭЦЭРЛЭГЧ ХҮҮ

Амараагийн аав нь байшингийнхаа урд наранцэцэг тарьжээ. Амараа найз Ганаатайгаа хамтран цэцгээ өдөр бүр усалж, салхинд хийсч ирсэн хогийг ч түүн цэвэрлэдэг байв. Цэцэг ургасаар дэлбээлжээ. Наранцэцэг нь нар гарахаар нарны өөдөөс дэлбээгээ дэлгэн улам сайхан харагдана. Нэгэн өдөр Амараа, Ганаа хоёр цэцэг услахаас болж муудалцжээ. Амараа уурласандаа Ганааг түлхтэл тэр хойшоо цэцгэн дээр нь уначихжээ.

Амраа:

-Хөөе, миний цэцгэн дээрээс босооч чи гэтэл

Ганаа:

-Яадаг юм гээд цэцгэн дээр нь гишгэчихээд гүйгээд одлоо.

Амараа уурлан цэцгийн ишийг нь дахин шороонд суулгажээ. Өглөө босоод цэцгээ услах гэтэл цэцэг нь ургахааргүй болжээ.

Ганаа, Амараагийн иртэл нь найз нь уйлчихсан, цэцэг нь хатаад бөхийчихсөн угтлаа.

Хамтдаа цэцгээ дахин суулгаж усалсан ч ургасангүй. Ингээд Амараа ээжээсээ цэцэг яагаад ургахгүй байгааг асуухад Ээж нь:

-Ургамлын эрхтэнгүүд гэмтвэл дахиж ургадаггүй юм гэлээ. Та хоёр муудалцаад эргээд эвлэрсэн нь сайн боловч цэцэг чинь ийм болсонд харамсалтай. Энэ цэцэг дахиад ургахгүй шүү дээ гэв. Амараа, Ганаа хоёр ямар их буруу зүйл хийснээ ухаарчээ. Ганаа гэмшин найзаасаа “Уучлаарай” гэж хэлээд гар барилцан тэд эвлэрлээ.



### ХУРУУН ХҮҮХЭЛДЭЙ

Цаасаар хуруун хүүхэлдэй хийх энэ арга нь хийхэд маш энгийн хялбар бөгөөд эвтэйхэн. Үүнийг хүүхдүүдтэйгээ хамтран хийхэд цаг ч бага орно. Хүүхэлдэйнүүдээ хүүхдүүдтэйгээ хамт тоглоход болон гэрийн театрт ашиглаж болно. Хүн, амьтан, шувуу, хүүхэлдэйн киноны баатар, тэр бүү хэл өөрсдийн зохиосон дүрдээ ч хувиргаж болох юм. Хүүхэлдэйн дүрсүүдийг зурж хайчлаад, хүүхдээр будуулаарай. Хүүхэлдэйгээ янз бүрийн зүйлсээр чимэглэж, харин үсийг ноосон утсаар хийж болно. Хамтдаа хийсэн хуруун хүүхэлдэйндээ үлгэр, түүх зохиож ярих боломжийг хүүхдэдээ өгөөрэй.





## ХҮҮХДИЙНХЭЭ ЦҮНХИЙГ ХЭРХЭН СОНГОХ ВЭ?

Манай улсын судлаачид 6 настай эрэгтэй хүүхдийн биеийн жин дунджаар 19.2 кг, эмэгтэй хүүхдийнх дунджаар 18.8 кг байдгийг тогтоожээ. Зарим улс оронд хүүхдийн цүнхний хүндийн жин нь тухайн хүүхдийн биеийн жингийн 10-15 хувиас хэтрэхгүй байх нь зохимжтой гэж үздэг байна. Хэрвээ түүнээс илүү жинтэй бол хүүхдэд хүчилтөрөгчийн нэмэлт хэрэгцээг бий болгодог байна. Иймд 6 настай сурагчийн цүнх 2кг-аас хэтрэхгүй жинтэй байх нь зохистой байна.

Нэгдүгээр ангийн сурагчийн цүнх зохист хэмжээнээс илүү хүнд байгаа нь тэдний бие бялдрын өсөлт, хөгжилд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй цаашид нурууны өвчлөлд өртөх эрсдэлтэй байдаг. Тиймээс эцэг эх та дараах зөвлөгөөний дагуу хүүхдийнхээ цүнхний жинг тохируулж байх нь зүйтэй.

### ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Хүүхдийн цүнх биед нь эвтэй байх нь тэдний эрүүл мэндэд маш чухал. Учир нь хүүхдийн цүнх тэдний нуруунд төдийгүй хүзүү, мөр, гар болон биеийн бусад хэсгийн хөгжилд ихээхэн нөлөөтэй.

### ХҮҮХДИЙНХЭЭ ЦҮНХИЙГ ЗӨВ СОНГОХОД ДАРААХ ЗҮЙЛСИЙГ АНХААРААРЙ:

- Хэт бариу оосортой цүнх нь хүүхэд чөлөөтэй амьсгалахад саад учруулдаг.
- Цүнхний өргөн мөрөвч нь түүний жин хүүхдийн биед жигд хуваарилагдахад тусалдаг.
- Цүнхний хажуугийн халаасуудад зарим эд зүйлсийг хийх нь цүнхний жинг хүүхдийн биед жигд хуваарилагдахад тусалдаг.
- Нуруундаа үүрдэг цүнх хоёр мөрөвчнөөс гадна бүсэлхийгээр бүслэх боломжтой байвал хүүхдийн биед эвтэй байдаг.
- Цүнхэнд хийх хүнд жинтэй, хавтгай зүйлсийг хүүхдийн нурууны талд хийх нь тохиромжтой.
- Аль болох хөнгөн материалтай, эдэлгээ сайтай хичээлийн хэрэгслийг сонгож хэрэглэх нь тохиромжтой.
- Хүүхдийн цүнхний жинд байнга хяналт тавьж өдөр бүр хэрэгтэй, хичээлд нь зайлшгүй хэрэгцээтэй зүйлсийг нь өгч явуулна.

